



**НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035  
Утас/Факс: (976-11) 32-71-99  
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2022.05.18 № 05/2491  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын зөвлөмжийг  
хэрэгжүүлэх тухай**

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн аудитын дүгнэлтээр төсвийн шууд захирагч нар цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг зөрүүтэй шилжүүлсэн, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан, үүссэн өр авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, өр авлагын үлдэгдлийг барагдуулдаггүй, батлагдсан норм нормативыг хэтрүүлсэн, төсвийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан зөрчлүүд илэрсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг таслан зогсоож, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах чиглэлийг өгч байна. Үүнд:

1.Засгийн газрын төсвийн хэмнэлтийн 2021 оны 43, 388 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлж төсвийг хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулах;

2.Цахим и-баримтыг бүрэн хөтөлж хэвшүүлэх;

3.Худалдан авах ажиллагааны журам заавар, зөрчиж шууд гэрээ байгуулж бараа, ажил үйлчилгээ худалдан авах,тендер зарлахаас зайлсхийж, тендерийг хувааж харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан зөрчлийг давтан гаргуулахгүй байх;

4.Засгийн газрын санхүүгийн удирдлагын нэгдсэн систем "Free balance" программаар гарч буй төсвийн гүйцэтгэлийг өөрийн байгууллагын санхүүгийн тайлангаар гарсан төсвийн гүйцэтгэлтэй тулган хянах;

5.Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, тогтмол байршуулж хэвшүүлэх;

6.Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого, зардлын данстай холбоотой ажил гүйлгээг холбогдох хууль, заавар, журам, УСНББОУС, НББОУС-ын дагуу үнэн, зөв тайлагнах, хөрөнгийн тооллого, тооцоог цаг тухайд нь хийж, үр дүнг санхүүгийн тайланд үнэн зөв тусгах;

7.Авлага, өглөгийн бүртгэлийг тооцоо нийлж баталгаажуулсны үндсэн дээр санхүүгийн тайланд тусгах, хугацаа хэтэрсэн өр авлагыг барагдуулах;

8.Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт болон нэмэлт дансны зарцуулалтын талаарх тайлбар танилцуулгыг орлого, зарлагын зүйл тус бүрээр дэлгэрэнгүй бэлтгэн гаргаж хэвших;

9.Санхүү, бүртгэлийн ажилтнуудыг мэргэжлийн чадавхыг сайжруулах сургалтад хамруулан мэргэшүүлэх.

Аудитын зөвлөмжийн биелэлтийг илэрсэн зөрчил нэг бүрээр гаргаж, үр дүнг 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор албан бичгээр болон файлаар ирүүлнэ үү.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.НАРАНБААТАР